

**Аймгийн удирдах ажилтнуудын 2023 оны 09 дугаар сарын 18, 10 дугаар сарын 02-ны өдрийн  
шуурхай зөвлөгөөнөөс өгсөн үүрэг, даалгавар**

2023.10.16

Чойр

№	Үүрэг даалгавар	Биелэлт	Хэрэгжилтийн хувь
1	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамрагдаагүй албан хаагчдаа хамруулах.	21 байгууллага үүргийн биелэлт ирүүлснээс 6 байгууллага эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамрагдаагүй 79 албан хаагч байна. Үүнд: Сүмбэр сум – 22 албан хаагч Баянтал сум – 16 албан хаагч Санхүүгийн хяналт, аудитын алба – 1 албан хаагч Мал эмнэлгийн газар – 2 албан хаагч Дуу бүжгийн Боржигин чуулга – 1 албан хаагч Ус-Ду ОНӨААТҮГ – 37 албан хаагч	70%
2	Өвөлжилтийн бэлтгэл ажлыг эрчимжүүлэх	Аймгийн хэмжээнд өвөлжилтийн бэлтгэл 80 хувьтай. Сүмбэр сум 51 хувьтай, Шивээговь сум 90 хувьтай, Баянтал сум 70 хувьтай байна. Аймгийн аюулгүйн нөөцөд 1884 тонн тэжээл байна. Сүмбэр сум 90 тонн өвс, 10 тонн тэжээл, Шивээговь сум 25 тонн өвс, 4,3 тонн тэжээл, Баянтал сум 19 тонн өвсний нөөцтэй байна. Сүмбэр сум 116700 толгой мал, Шивээговь сум 20450 толгой мал, Баянтал сум 23000 толгой малыг ариутгалын угаалгад оруулаад байна. Шивээговь сумын дулааныг хангах байгууллага болох “Илчлэг Шивээ” ОНӨААТҮГ-ын өвөлжилтийн бэлтгэл ажил 100%-тай хангагдсан байна. Ус-Ду ОНӨААТҮГ өвөлжилтийн бэлтгэлд нийт 21 ажил төлөвлөн 17 ажил 100 хувь, 1 ажил 70 хувь, ажлын гүйцэтгэл 84.2 хувьтай байна. Талын Илч ОНӨААТҮГ газар нь сумын төвийн гадна болон дотор шугам, орон сууцны сантехникийн шугам хоолой, халаалтын зуух зэрэг инженерийн шугам сүлжээний засварын ажлыг 100 хувь хийж дуусгасан.	72.75%
3	13А маягтын асуудлыг орон нутагт хүндрэл үүсгэхгүйгээр шийдвэрлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх	Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2023 оны 08 дугаар тогтоолоор нийт 14 төрлийн тусламж үйлчилгээнд 13А шилжүүлгийн маягт шаардахгүйгээр заасан. Үүнд: 1. Халдварт өвчин	70%

		<p>2. Шүд амны хөндий  3. Чих хамар хоолойн өвчин  4. Хорт хавдар  5. Осол гэмтэл  6. Арьс харшил  7. Сэтгэц, зан үйлийн эмгэг  8. Уламжлалт ангаах ухаан  9. Сэргээн засах  10. Амбулаториор хийгдэх мэс засал  11. Нүдний тусламж үйлчилгээ  12. Мэс заслын тусалж үйлчилгээ  13. Диализын тусламж үйлчилгээ  14. Амбулаторийн хяналтын үзлэг</p> <p>Эдгээр 14 нэр төрлийн эмнэлгийн тусламж үйлчилгээ дээр нэмэгдэж Эрүүл мэндийн сайдын 2023 оны 09 сарын 05-ны өдрийн 5/4024 тоотор 4 тусламж үйлчилгээнд 13А шилжүүлгийн маягт шаардахгүй болсон.</p> <p>Үүнд:</p> <p>1. Жирэмсэн эмэгтэйчүүд  2. 18 хүртэлх насны хүүхэд  3. Эмнэлгийн байгууллагаас үргэлжлэх шатны хяналтын давтан үзлэгт орох шаардлагатай иргэдэд  4. Эмнэлэг дотроо бусад кабинет, тасгаар үйлчлүүлэхэд 13А шилжүүлгийн маягтад өөрчлөлт орсон мэдээлэл ирээгүй байна.</p>	
4	Нийгмийн иновацийг дэмжих “МОН ИКС” хөтөлбөрийн танилцуулах сургалтад албан хаагчдаа хамруулах	Нийгмийн иновацийг дэмжих “МОН ИКС” хөтөлбөрийн танилцуулах сургалт зохион байгуулагдан 13 байгууллагын 35 албан хаагч, хувийн хэвшлийн 49 иргэн хамрагдсан. Говьсүмбэр аймгийн хэмжээнд “МОН ИКС” хөтөлбөрийн 5 төслийн санал илгээсэн.	70%
5	Багийн Засаг дарга нарыг үүрэгжүүлж, хариуцлагажуулж ажлын үр дүнг тооцож улирал тутамд танилцуулж ажиллах, амралтыг дуусгаж ажилд нь оруулах	<p>Сүмбэр сумын ээлжийн амралттай байсан 3 болон 5 дугаар багийн Засаг дарга нар ажилд нь оруулсан ба ажил танилцуулах хугацаа болоогүй байна.</p> <p>Шивээговь сумын хэмжээнд Нэрт болон Бэхт гэсэн 2 баг байдаг ба тус 2 багийн даргатай оны эхэнд хамтран ажиллах гэрээ үйлдэж,</p>	50%

		<p>гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлан хагас бүтэн жилээр багийн Иргэдийн Нийтийн хурлаар иргэдэд болон сумын Засаг даргад тайлагнадаг.</p> <p>Баянтал сумын 1 дүгээр багийн Засаг дарга ээлжийн амралтаа дуусгаж ажилдаа орсон. 2023 оны 2 дугаар ээлжийн цэрэг татлагын бэлтгэл ажлыг хангуулахаар Багийн засаг дарга нарт үүрэг өгч ажиллаж байна.</p>	
6	Аймгийн Засаг дарга болон Засаг даргын орлогчийн 2023 оны 10 дугаар сард оролцох арга хэмжээний мэдээллээ ТЗУХ-т ирүүлэх	<p>Байгаль орчин, аялал жуулчлалын газар 10 сарын 12-ны өдөр Зөв дадал эерэг өөрчлөлт ногоон ирээдүй аяны тайлант өдөрлөг арга хэмжээ, Соёл урлагийн газар ганжуур эргэх ёслол, Боржигдай сэцэн Монгол туургатны яруу найргийн наадам, Оюуны элч MIND UPDATE 21 аймгийн хэрэгжсэн төслийн хүрээнд шилдгээр шалгарсан аймагт 2000 ном гардуулах үйл ажиллагааг Аймгийн Засаг дарга болон Засаг даргын орлогчийн 2023 оны 10 дугаар сард оролцох арга хэмжээний мэдээллийг ирүүлсэн.</p>	100%
7	Малын угаалгатай холбоотой судалгаа, мэдээллийг Цагдаагийн хэлтэс хүргүүлэн, танилцуулах	<p>Сүмбэр сум малын угаалгатай холбоотой судалгаа, мэдээллийг 2023 оны 09 сарын 22-ны өдрийн А/589 дугаар албан бичгээр Цагдаагийн хэлтэст хүргүүлсэн. 116700 толгой мал угаалгад оруулсан.</p> <p>Шивээговь сум мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг хангуулахаар III улирлын байдлаар 3 өрхийн хонь-995, ямаа-810, нийт-1805 толгой малыг мал угаалгад оруулсан. Мөн 22 өрхийн хонь-12200, ямаа-8210, үхэр-40 нийт-20450 толгой малыг ариутгалын бодисоор шүршээд байна. Нийт 22255 малыг малыг ариутгал угаалгад оруулаад байна.</p> <p>Баянтал сум “ХИЛИЙН ДЭЛГЭРЭХ” ХХК мал эмнэлэгт 2023 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн байдлаар нийт 23000 толгой бог малд угаалга хийсэн.</p>	70%
8	СӨХ шинээр байгуулах ажлыг эрчимжүүлэх	<p>Баруун зүүн өмнөд бүсийн Цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ний Говьсүмбэр аймаг дахь салбарт Найрамдал хотхоны 900 өрхийн СӨХ-ийн төлбөрийг гэрэл цахилгааны төлбөртэй хамтран хураах хүсэлтийг 2023 оны 09 сарын 20-ны өдөр албан бичгээр хүргүүлсэн.</p>	30%

9	“Боржигин өв соёл” эвэнт арга хэмжээнд байгууллагууд оролцох	<p>“Боржигин өв соёл” эвэнт арга хэмжээний хүрээнд 10 гэр барьж тохижуулан ирсэн зочдод хоол цайгаар үйлчилсэн. Цагдаагийн хэлтэс хамгаалалтын хашаа 110 метр, олс 1500 метр, шон 200 ширхэг, зогсоолын 4 тэмдгийг байршуулан аюулгүй байдлыг хангасан. Байгаль орчин, аялал жуулчлалын газар 8ш эко 00 , эрэгтэй 12 ш шээлтүүр байршуулж, 3ш хогийн үүрдэг пүнкер , түрдэг хогийн сав 8ш , 10 хүний бүрэлдэхүүнтэй ажилласан. Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар шагай тойромын зохион байгуулалтад хамтарч ажилласан. Боржигин өв музей Монгол Улсын Гавьяат Ишдазангын Цогбадрахыг алдаршуулах сурталчлах зорилгоор “Боржигин морин хуур” нүүдлийн үзэсгэлэнг зохион байгуулж, үзэсгэлэнг нийт 215 иргэнд үзүүлсэн байна. АЗДТГ Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс Баруун зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ Говьсүмбэр салбараас отгийн цахилгаан хангамжийг тасралтгүй байдлыг хариуцаж 2 монтёр, генератор хариуцсан 1 ажилтан ажиллан, генератор цахилгааны утсаар хангаж ажилсан. Хууль эрх зүйн хэлтэс, Төрийн захиргаа удирдлагын хэлтэс, Хөгжлийн бодлого төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтсүүд гэр барих буулгах, ширээ сандал ачих буулгах, тайз угсрах ачих, ирсэн иргэдэд сандалд суудаг ажлуудыг хариуцан ажилсан.</p>	90%
<b>Дундаж</b>		77.8	

**Хянасан:**

ХШҮ-ний хэлтсийн дарга:

М.АНХБАЯР

**Үүргийн биелэлт нэгтгэж, үнэлсэн:**

ХШҮ-ний хэлтсийн мэргэжилтэн

Б.МӨНХЗАЯА